



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 11 сарын 17 өдөр

Дугаар

Х/503

Арвайхээр

**Эрх шилжүүлэх тухай**

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 178 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн, (COVID-19) цар тахлын халдвар дотоодод илэрсэнтэй холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 13/03 дугаар тогтоолын хавсралт 2-т тусгагдсан Арвайхээр сумын нөөцийн мах бэлтгэх зардал 100,000,000 (нэг зуун сая) төгрөгийн зарцуулах эрхийг Арвайхээр сумын Засаг дарга Б.Ганбатад шилжүүлсүгэй.

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу онцгой нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан шууд гэрээ байгуулж, бараа нийлүүлэлтийн чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, хүлээн авахыг Арвайхээр сумын Засаг дарга (Б.Ганбат)-д даалгасугай.

3. Дээрх зардлыг аймгийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101133